



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/259
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛ СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ХАРЪЯА
ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН
СУРГАЛТТАЙ "ШИНЭ ЭРИН
ЛАБОРАТОРИ СУРГУУЛЬ"-ИЙН
ЗАХИРАЛ Б.АМАРТҮВШИН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал юм.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"БСШУСЯ-ны харъяа олон улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



СӨНХЗАЯА



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“БСШУСЯ-ны харъяа олон улсын хөтөлбөрийн сургалттай шинэ эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын дарга

тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа

Утас: 261885

Цахим хаяг:

Аудитор: Ахлах аудитор

Д.Ганбилэг

Утас: 260512

Цахим хаяг:

ganbilegd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IY

байр, Бага тойруу-6, УБ-46

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын гэрчилгээ

Хавсралт 1: Агуулга.....1-9

Хавсралт 2: Менежментийн захидал.....10-14

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....15-20

Хавсралт 4. “БСШУСЯ-ны харъяа олон улсын хөтөлбөртэй
сургалтын Шинэ эрин лаборатори сургууль”
2016 оны санхүүгийн тайлан, санхүүгийн
тайлангийн тодруулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөрчилгүй санал дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8.9.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 20-ны А/98 дугаар тушаал, Үндэсний аудитын газрын 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн “Аудитын хуваарь хүргүүлэх тухай” 3/1335 дугаар албан бичгийн дагуу Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам”-ын 2.7 дугаар заалтыг үндэслэн Үндэсний аудитын газраас олгосон эрхийн хүрээнд “БСШУСЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2016/48/СТА-ГАК-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“БСШУСЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус сургуулийн удирдлага санхүүгийн тайлангаа НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн “Санхүүч-Аудит” ХХК-ний аудитын багийн гишүүн аудитор Д.Лхамсүрэн, Б.Энхсүрэн нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“БСШУСЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 10-нд “Санхүүч-Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Санхүүч-Аудит” ХХК тус сургуулийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг төлөвлөлт, гүйцэтгэл буюу объект, тайлагнал гэсэн үе шатуудаар 2016 оны 9 дүгээр сарын 23-наас 2017 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-нд “БСШУСЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“БСШУСЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль” нь Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд “Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын боловсролын түүхнээ нэгэн шинэ хуудас болсон, улсын анхны төрийн өмчит олон улсын хөтөлбөрийн сургалттай энэ сургууль нь 2010 оны 11 сард байгуулагджээ. Энэ хугацаанд тус сургуулийн хамт олон, суралцагчид, эцэг эхчүүд, гадаад дотоодын хамтран ажилладаг байгууллагуудын хамтын хүч хөдөлмөрөөр олон зүйлийг амжуулж, олон улсын жишигт хүрсэн сургалт, судалгааны төв бүхий загвар сургуулийн түвшинд хүрч чадсан.

Манай улсад боловсролын чанарын шинэчлэл хийхээр зорьж буй энэ цаг үед олон улсын жишиг болсон хөтөлбөр, арга зүй, сургалтын технологи, менежмент, судалгааг өөрийн сургалтын онцлогт нийцүүлэн нутагшуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байгаа гэсэн дүгнэлттэйгээр ажиллаж байна.

Тус сургууль анх 2010 онд 40 сурагч, 13 багш, 3 удирдах ажилтантай үүсгэн байгуулагдаж байсан бол өдгөө олон улсын стандарт, шаардлагыг бүрэн хангасан барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, орчин нөхцөл бүхий 3 сургууль, монгол улсын болон олон улсын хөтөлбөрийн судалгаа хийж, сургалтанд хамрагдаж мэргэшсэн 100 гаруй монгол, гадаад багш, ажилтнуудтай болж өргөжсөн байна. БШУСайдын тушаалаар батлагдсан үндэсний хөтөлбөрийг шинэчлэх багуудад олон улсын хөтөлбөрийн сургалттай лаборатори сургуулиудын багш нар, боловсролын менежментийг шинэчлэх ажлын хэсэгт дээрх сургуулиудын удирдлагууд ажиллаж, үндэсний боловсролын тогтолцоог шинэчлэх ажилд идэвхийлэн оролцож байна. Мөн улсын, бүсийн, нийслэлийн хэмжээний багшийн мэргэжил дээшлүүлэх болон туршлага судлах сургалт, хурал, уулзалт, хэлэлцүүлгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн заалт чиглэлийг тус байгууллага үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу “Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн захирал нь Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийн санхүүжилтыг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд тус байгууллагатай холбоотой заалтууд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд хэрэгжиж байна. Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаандаа мөрддөг голлох хуулиуд болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиудад өөрчлөлт ороогүй байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “БСШУСЯ-ны харьяа Шинэ Эрин олон улсын лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс тус байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, орлого, зардал дансдад аудитын хяналтын горим, нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “БСШУСЯ-ны харьяа Шинэ Эрин олон улсын лаборатори сургууль”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УНББОУС-тай нийцэж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн программ уялдсан байна.

Тус сургуулийн ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Шинэ Эрин олон улсын лаборатори сургууль”-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67-р зүйлд зааснаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтын ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч дотоод хяналтын чиглэлээр мэргэжлийн ажилтан байхгүй.

Материаллаг байдал

Төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үзэх учраас материаллаг байдлыг тооцоолох суурийг 2016.12.31-ээрх нийт зарлагын дүнгээс тооцоолсон. Материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1.0 хувиар буюу 9,168.8 мянган төгрөгөөр тогтоосон болно.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу БСШУСЯ-ны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Шинэ Эрин олон улсын лаборатори сургууль” нь 2016 оны улсын төсвөөс урсгал зардалд 799,105.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт /төсөвт урамшуулал/ 7,171.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний орлогоор 4,009.1 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал

зардалд 801,411.5 мянган төгрөг зарцуулахаар батлагдсанаас 799,105.5 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 2,306.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль нь 2014 оны 07 дугаар сарын 01-ны өдөр батлагдаж 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа.

Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

“БСШУСЯ-ны харъяа Шинэ эрин олон улсын лаборатори сургууль” нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу өөрийн <http://newera.edu.mn/> цахим хуудсанд “Шилэн данс” гэсэн тусдаа бие даасан цэс байрлуулж Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны 384 тоот тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хавсралтад заасан маягтын дагуу хүснэгтэн мэдээллүүдийг оруулахаар бэлтгэсэн байна.

Шилэн дансны хуулийн дагуу 2016 оны төсвийн төлөвлөгөө шивэн оруулсан байна. Энэ нь цалингаас өөр 5.0 саяаас дээш дүнтэй гүйлгээ гаргаагүй байна.

Тус сургуулийг Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж байна гэж үзэж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэлийг тогтоож батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт хяналтын 7 горим, сорил /ТАБ-СТА-В-3/ гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

“БСШУСЯ-ны харъяа Шинэ Эрин олон улсын лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад бүхий л ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

Тухайлбал:

1. БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ “Эрин” лаборатори сургууль нь Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох 154 м2 талбай бүхий өрөөг цайны газрын зориулалтаар Халиунбат Арвижих” ХХК-д түрээслүүлсэнээс 552.6 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг тус компаниас төлүүлэн аваагүй байна.

Шийдвэрлэсэн:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

2016 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд бараа материалын дансанд бүртгэгдэх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн нийт 49,778.1 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулахыг зөвшөөрөв.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Олон улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээн мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт бараа материалын дансанд бүртгэгдэх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн нийт 49,778.1 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн өмчит “БСШУСЯ-ны харъяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2015 оны санхүүгийн тайланд “Санхүүч Аудит” ХХК-аас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн Асуудал 1 ба 2-ыг хэрэгжүүлж, Бараа материалын /тусгай зориулалттай материал, хангамжийн материал/ дансанд бүртгэгдэх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Үүнд: Машин тоног төхөөрөмжийн дансанд 18 нэр төрлийн 44 ширхэг 1,362.6 мянган төгрөг, тавилга, эд хогшлийн дансанд 211 нэр төрлийн 2454 ширхэг 48,415.5 төгрөгийн материал, нийт 49,778.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Үүнийг хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“БСШУСЯ-ны харъяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургууль”-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, БСШУСЯ-ны харъяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Шинэ Эрин лаборатори сургуулийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга 17 хуудсыг тус тус хавсаргав.



БСШУСЯ-НЫ ХАРЪЯА ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ “ШИНЭ ЭРИН ЛАБОРАТОРИ СУРГУУЛЬ” -ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын дарга
тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер Н.Золзаяа
Утас: 261885
Цахим хаяг:

Аудитор: Ахлах аудитор Д.Ганбилэг
Утас: 260512
Цахим хаяг:
ganbilegd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IY
байр, Бага тойруу-6, УБ-46
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн
“Санхүүч-Аудит” ХХК
Захирал: Б.Алтантуяа
Утас: 77116177
Цахим хаяг:
info@sankhuuch-audit.mn

Захирал: Б.Алтантуяа
Утас: 99058199
Sondor_1@yahoo.com
Аудитор: Д.Лхамсүрэн
Аудитор: Г.Бэлэгт
“Санхүүч-аудит” ХХК хаяг:
Москва төв, СХД-29 хороо,
Улаанбаатар хот.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Асуудал-1: Бусдаас авах авлагын талаар

2017 оны 02 дугаар сар

Менежментийн захидал

Төрийн аудитын тухай хуулийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8.9.8, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 20-ний А/98 дугаар тушаал, Үндэсний аудитын газрын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн “Аудитын хуваарь хүргүүлэх тухай” 3/1335 тоот албан бичгийг үндэслэн танай байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, санхүүгийн тайлангийн аудитын атны ажлыг гүйцэтгэлээ.

Бид танай байгууллагын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын тогтолцоо, хэрэгжүүлдэг горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд хянасан бөгөөд бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг байгууллагын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно. Эдгээр зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготойгоор хүргүүлж байгаа бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан төрийн өмчит БСШУСЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ эрин лаборатори сургууль”-ийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Бусдаас авах авлагын талаар

Ажиглалт

БСШУСЯ-ны харьяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ “Эрин” лаборатори сургууль нь Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох 154 м2 талбай бүхий өрөөг цайны газрын зориулалтаар Халиунбат Арвижих” ХХК-д түрээслүүлсэнээс 552.6 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг тус компаниас төлүүлэн аваагүй байна.

Эрсдэл.

- Найдваргүй авлага нэмэгдэж хөрөнгө зүй бусаар зарцуулагдах
- Хууль зөрчигдөх

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу.

2015 оны түрээсийн төлбөр болох 552.6 мянган төгрөгийг 2017 оны 03-р сард багтаан төлүүлнэ.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлант жил

/төгрөгөөр/

Дансн ы код	ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		1,488,002.00	-
	Кассанд байгаа бэлэн мөнгө		1,488,002.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	1		-
33	АВЛАГА		670,151.09	852,621.09
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага			300,000.00
335	Бусад авлага		670,151.09	552,621.09
35	БАРАА МАТЕРИАЛ		71,468,188.88	94,950,008.04
351	Түүхий эд материал		32,695,860.88	50,981,037.14
354	Хангамжийн материал	2	38,772,328.00	43,968,970.90
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		73,626,341.97	95,802,629.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		2,511,441,492.47	2,454,414,462.59
3902	Биет хөрөнгө		2,486,783,123.31	2,438,279,411.91
39201	Барилга, байгууламж	3	2,049,844,964.00	2,049,844,964.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(81,192,230.45)	(115,356,313.13)
39203	Авто тээврийн хэрэгсэл	4	60,800,000.00	60,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(29,386,666.62)	(39,519,999.90)
39205	Машин, тоног төхөөрөмж	5	365,164,091.98	407,755,611.87
39206	Хуримтлагдсан элэгдэл		(226,705,048.15)	(245,278,633.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6	442,994,886.70	469,421,581.06
39208	Хуримтлагдсан элэгдэл		(182,552,515.14)	(236,345,439.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө		8,800,000.00	8,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(879,999.96)	(1,759,999.92)
39217	Номын фонд		79,895,640.95	79,917,640.95
393	Биет бус хөрөнгө		24,658,369.16	16,135,050.68
39301	Програм хангамж	7	48,767,381.74	48,767,381.74
39302	Хасагдуулга		(24,109,012.58)	(32,632,331.06)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,511,441,492.47	2,454,414,462.59
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2,585,067,834.44	2,550,217,091.72
413	Өглөг		11,139,928.01	4,491,331.00
4131	Ажиллагсадтай холбогдсон өглөг		11,139,928.01	12,000.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг			4,479,331.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		11,139,928.01	4,491,331.00
51101	Төрийн өмч		3,132,187,517.32	3,132,187,517.32
51210	Өмнөх үеийн үр дүн		(558,259,610.89)	(558,259,610.89)
51220	Тайлант үеийн үр дүн			(28,202,145.71)
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН			2,545,725,760.72
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		2,585,067,834.44	2,550,217,091.72

БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлант жил

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО			
130301	Улсын төсвөөс	10	781,096,450.00	800,861,500.00
13030101	Урсгал		781,096,450.00	800,861,500.00
13030114	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	7,171,853.18
1303011403	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс			720,000.00
1303011404	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи			6,000,000.00
1303011406	Төсвийн урамшуулал			451,853.18
	Төсвийн захирагчдаас		1,491,853.18	-
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,491,853.18	
	Бараа, үйлчилгээний орлого	11	4,016,305.00	80,642,668.98
140201	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		12,705.00	4,009,131.47
14020105	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого			76,633,537.51
	Түрээсийн орлого		4,003,600.00	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		786,604,608.18	888,676,022.16
	УРСГАЛ ЗАРДАЛ		986,797,141.91	909,625,000.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		985,232,837.42	909,625,000.67
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	12		688,634,631.35
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		625,903,017.00	619,874,683.35
210101	Цалин		625,903,017.00	619,874,683.35
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл		69,221,825.56	68,759,948.00
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл		57,354,657.56	56,902,302.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		44,780,657.56	44,445,208.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		3,352,705.00	3,301,960.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		6,261,415.00	6,191,876.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		2,959,880.00	2,963,258.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		11,867,168.00	11,857,646.00
2103	Тогтмол зардал		32,070,704.84	43,452,892.25

210301	Гэрэл цахилгааны зардал		16,181,703.00	16,711,504.00
210302	Түлш, халаалтын зардал		13,942,418.84	23,351,731.40
210303	Цэвэр, бохир усны зардал		1,946,583.00	3,389,656.85
2104	Хангамж, бараа материалын зардал		17,538,757.36	22,913,699.67
210401	Бичиг хэргийн материал		4,105,408.00	3,583,063.00
210402	Тээвэр, шатахууны зардал		5,461,604.28	4,449,300.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр		5,293,189.08	12,433,630.48
210404	Ном, хэвлэлийн зардал		240,700.00	139,400.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		2,437,856.00	2,308,306.19
	Нормативт зардал		610,140.00	188,628.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		610,140.00	188,628.00
	Эд хогшил, урсгал засварын зардал		6,536,150.00	3,499,350.00
210604	Урсгал засвар		6,536,150.00	3,499,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж		17,445,033.00	10,033,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил		2,977,101.00	4,668,452.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		131,900.00	131,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		16,500.00	54,800.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		12,319,532.00	3,178,826.00
220103	Бараа үйлчилгээний бусад зардал		215,907,209.66	140,901,821.40
	Бараа үйлчилгээний бусад зардал		1,126,002.00	
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		21,166,979.80	14,834,577.27
(210903)	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		193,614,227.86	126,067,244.13
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13	1,564,304.49	7,253,167.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		1,564,304.49	7,253,167.20
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		200,000.00	
(213303)	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,364,304.49	7,253,167.20
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		986,797,141.91	916,878,167.87
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		(200,192,533.73)	-28,202,145.71

БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлант жил

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1					
2	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл				
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын еерчлелт				
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
5	Үндсэн херенгийн дахин үнэлгээний есөлт				
6	Үндсэн херенгийн дахин үнэлгээний бууралт				
7	Орлогын тайланд хилээн зөвшөөрөөгүй олз,гарз				
8	Тайлант үеийн үр дүн				
9	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,132,187,517.32		(558,259,610.89)	2,573,927,906.43
10	2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл				
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын еерчлелт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн херенгийн дахин үнэлгээний есөлт бууралт				
14	Үндсэн херенгийн есөлт бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,гарз				
16	Тайлант үеийн үр дүн			(28,202,145.71)	(28,202,145.71)
17	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,132,187,517.32		(586,461,756.60)	2,545,725,760.72

-

БСШУСЯ-ны харъяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлант жил

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
13	Тусламж, санхүүжилтын орлого	782,588,303.18	828,410,005.18
	Улсын төсвөөс	781,096,450.00	800,861,500.00
13030101	Урсгал	781,096,450.00	800,861,500.00
13030114	Нэмэлт санхүүжилтийн орлого		7,171,853.18
1303011403	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		720,000.00
1303011404	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		6,000,000.00
1303011405	Төсвийн урамшуулал		451,853.18
14	Төсвийн захирагчдаас	1,491,853.18	
1402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,491,853.18	
14020104	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		20,376,652.00
14-140201	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		20,376,652.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,016,305.00	4,009,131.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,705.00	4,009,131.47
120005	Түрээсийн орлого	4,003,600.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	786,604,608.18	832,419,136.65
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,008,867.84	824,395,971.45
	Ажиллагчидтай холбогдсон зардал	631,908,873.06	651,410,837.91
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	631,908,873.06	651,410,837.91
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	67,403,197.56	68,910,843.45
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	67,403,197.56	68,910,843.45
	Бараа үйлчилгээний урсгал зардал		29,041,019.23
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	32,070,704.84	43,452,892.25
210301	Гэрэл цахилгааны зардал	16,181,703.00	16,711,504.00
210302	Түлш, халаалтын зардал	13,942,418.84	23,351,731.40
210303	Цэвэр, бохир усны зардал	1,946,583.00	3,389,656.85
2104	Хангамж, бараа материалын зардал	12,908,509.08	17,806,354.67
210401	Бичиг хэрэг	3,256,015.00	4,208,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,067,800.00	4,481,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,293,189.08	7,954,299.48
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,050,805.00	935,255.19
	Ном, хэвлэл	240,700.00	227,400.00
2105	Нормативт зардал	454,988.00	808,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	454,988.00	808,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,861,850.00	6,214,600.00
210604	Урсгал засвар	6,861,850.00	6,214,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,192,015.00	11,286,708.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	3,670,501.00	5,609,382.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	131,900.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,500.00	54,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,373,114.00	3,490,626.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,208,730.30	24,505,235.17
	Бараа үйлчилгээний бусад зардал	498,500.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	19,710,230.30	24,505,235.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,564,304.49	7,253,167.20
2131	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	200,000.00	6,449,578.81
213101	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,364,304.49	6,449,578.81
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (1)	784,573,172.33	831,649,138.65
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,031,435.85	769,998.00
	Хөрөнгийн орлого	00.00	-
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	850,000.00	2,258,000.00
2	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	850,000.00	2,258,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	850,000.00	2,258,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛ	(850,000.00)	(2,258,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН Г	00.00	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,181,435.85	(1,488,002.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,488,002.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

-

БСШУСЯ-ны харьяа Олон Улсын хөтөлбөрийн сургалттай "Шинэ Эрин лаборатори сургууль"

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлант жил

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ		ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	801,411,500.00	799,105,466.45	2,306,033.55	99.71
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	801,411,500.00	799,105,466.45	2,306,033.55	99.71
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	801,411,500.00	799,105,466.45	2,306,033.55	99.71
Бараа, үйлчилгээний зардал	800,861,500.00	799,105,466.45	1,756,033.55	99.78
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,930,700.00	630,704,185.91	226,514.09	99.96
Үндсэн цалин	586,276,800.00	630,704,185.91	(44,427,385.91)	107.58
Нэмэгдэл	12,132,400.00		12,132,400.00	00.00
Унаа, болон бусад нөхөн олговор	2,672,100.00		2,672,100.00	00.00
Урамшуулал	29,849,400.00		29,849,400.00	00.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,221,300.00	68,910,843.45	310,456.55	99.55
Тэтгэврийн даатгал	69,221,300.00	68,910,843.45	310,456.55	99.55
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,452,900.00	43,452,892.25	7.75	100.00
Гэрэл цахилгаан	16,468,900.00	16,711,504.00	(242,604.00)	101.47
Түлш, халаалт	23,594,400.00	23,351,731.40	242,668.60	98.97
Цэвэр, бохир ус	3,389,600.00	3,389,656.85	(56.85)	100.00
Хангамж, бараа материалын зардал	17,834,600.00	17,828,354.67	6,245.33	99.96
Бичиг хэрэг	4,209,100.00	4,208,400.00	700.00	99.98
Тээвэр (шатахуун)	4,484,600.00	4,481,000.00	3,600.00	99.92
Шуудан холбоо	7,954,300.00	7,954,299.48	0.52	100.00
Ном, хэвлэл	249,400.00	249,400.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	937,200.00	935,255.19	1,944.81	99.79
Нормативт зардал	816,000.00	808,500.00	7,500.00	99.08
Нормын хувцас зөөлөн эдлэл	816,000.00	808,500.00	7,500.00	99.08
Эд хогшил худалдан авах	7,349,500.00	6,214,600.00	1,134,900.00	84.56
Урсгал засвар	7,349,500.00	6,214,600.00	1,134,900.00	84.56
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,287,600.00	11,286,708.00	892.00	99.99
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,610,200.00	5,609,382.00	818.00	99.99
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	131,900.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,800.00	54,800.00	-	100.00
Мэдээлэл технологийн зардал	3,490,700.00	3,490,626.00	74.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,007,600.00	1,006,500.00	1,100.00	99.89
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,968,900.00	19,899,382.17	69,517.83	99.65
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	550,000.00		550,000.00	00.00
Бусад урсгал шилжүүлэг	550,000.00		550,000.00	00.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	550,000.00		550,000.00	00.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	800,861,500.00	797,617,464.45	3,244,035.55	99.59
Төсвөөс санхүүжих	800,861,500.00	793,608,332.98	7,253,167.02	99.09
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		4,009,131.47	(4,009,131.47)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,009,131.47	(4,009,131.47)	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,488,002.00	(1,488,002.00)	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАД БҮГД	56.00	56.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /Нэмэлт санхүүжилт/

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлант жил

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,171,853.00	(7,171,853.00)	
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		7,171,853.00	(7,171,853.00)	
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		7,171,853.00	(7,171,853.00)	
Бараа, үйлчилгээний зардал	-	7,171,853.00	(7,171,853.00)	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		330,000.00	(330,000.00)	
Үндсэн цалин		330,000.00	(330,000.00)	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,841,853.00	(6,841,853.00)	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,841,853.00	(6,841,853.00)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,171,853.18	(7,171,853.18)	
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц		720,000.00	(720,000.00)	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчийн нөөц		6,000,000.00	(6,000,000.00)	
Төсвийн урамшуулал		451,853.18	(451,853.18)	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
АЖИЛЛАГСАД БҮГД	56.00	56.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00